

# КОДИФИКАЦИЙГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)<sup>1</sup>

## НЭГ. УДИРТГАЛ

Хууль зүйн шинжлэх ухаан дахь эрх зүйн системчлэл гэсэн өргөн хүрээний ойлголтын нэг хэсэг нь хууль тогтоомжийн системчлэл юм. Хууль тогтоомжийн системчлэл гэж албан ёсоор хүчингүйд тооцоогүй бөгөөд хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа хууль, эрх зүйн хэм хэмжээ бүхий актуудыг нийгмийн амьдралын хүрээгээр буюу эрх зүйн салбараар төрөлжүүлэн нэгтгэх, эмхлэн цэгцлэх үйл ажиллагааг хэлнэ.<sup>2</sup>

Энэхүү хууль тогтоомжийн системчлэл нь эрх зүйн үйл ажиллагааны бие даасан дөрвөн хэлбэрээс бүрдэг ба тэдгээр үндсэн аргын<sup>3</sup> нэг нь хууль тогтоомжийн кодификаци болно. Тус судалгаанд хууль тогтоомжийн кодификацийн талаарх ерөнхий ойлголт, өнөөгийн нөхцөл байдал болон кодификацийг амжилттай хэрэгжүүлж буй гадаад улсын сайн туршлагын талаар судалж, үндэсний эрх зүйд нутагшуулах арга зам, хандлагыг эрэлхийлэхийг зорилоо.

Ингэхдээ кодификаци буюу хууль тогтоомжийг системчлэн нэгтгэж буй техник ажиллагааны талаар түлхүү судалсан бөгөөд кодификацийн нэг хэсэг болох төрөлжсөн хууль (кодекс)-ийн агуулгын талаарх ойлголтыг хамааруулаагүй болно.

## ХОЁР. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

### 2.1. Ерөнхий ойлголт, түүхэн хөгжил

Хууль тогтоомжийг системчлэх ажиллагаа нэг удаагийн үйл ажиллагаа бус байнгын шинжтэй, тогтмол ажиллагаа юм. Нийгмийн харилцаагаа дагаад хууль бүтээх ажиллагаа байнга явагдана.<sup>4</sup> Хууль тогтоомж нь өөр өөр хугацаанд батлагдсан, нарийвчилсан хэд хэдэн хэм хэмжээ тогтоосон байдаг. Ийм байдал нь тэдгээрийг олж мэдэх, зөв хэрэглэхэд бэрхшээл учруулдаг. Тиймээс ч хууль тогтоомжийг системчлэх шаардлага бий болдог<sup>5</sup> байна.

Дэлхийн эрх зүйн түүхийн хөгжлийн явцад “Кодификаци” (англ. *Codification*)-ийг “Кодекс” буюу төрөлжсөн хуулийн талаас нь түлхүү судалж, ойлгож ирсэн байх бөгөөд энэ нь шууд утгаараа “хууль тогтоомжийг агуулга болон тодорхой салбар эрх зүйгээр нэгтгэж, төрөлжүүлэн хуульчлах арга<sup>6</sup> буюу хууль тогтоох байгууллагаас баталж буй үйл ажиллагаа”

---

<sup>1</sup> Тус судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Халиунаа удирдаж, Эрдэм шинжилгээний ажилтан Ц.Оюунчимэг, С.Цэрэндолгор нар хамтран гүйцэтгэв.

<sup>2</sup> О.Амархүү, *Эрх зүйн онолын арван таван сэдэв* (УБ: Адмон хэвлэл, 2008), 59 дэх тал.

<sup>3</sup> Системчилсэн эмхэтгэлийг бэлтгэхэд а/ инкорпорац, б/ кодификаци гэсэн үндсэн хоёр аргыг түлхүү хэрэглэдэг.

<sup>4</sup> Д.Лүндээжанцан, *Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник* (УБ: ВСИ хэвлэл, 2016), 119 дэх тал.

<sup>5</sup> О.Амархүү, *Эрх зүйн онолын арван таван сэдэв* (УБ: Адмон хэвлэл, 2008), 59 дэх тал.

<sup>6</sup> Мөн тэнд.

юм. Гэвч кодекс буюу төрөлжсөн хууль нь кодификацийн гагцхүү нэг хэсэг бөгөөд эрх зүйн актыг системчлэх ажиллагааг мөн кодификацид хамруулан ойлгох учиртай.

Иймд дурдсан агуулгын хүрээнд авч үзвэл, хэдий кодификацид кодекс хамаардаг боловч кодификаци нь илүү өргөн хүрээтэй ойлголт бөгөөд үүнийг уламжлалт утгаар нь авч үзэхээс гадна эрх зүйн актын системчлэл талаас нь судлах шаардлагатай. Өнөөдрийн байдлаар кодификацийг өргөн утгаар нь буюу эрх зүйн актын системчлэл болон төрөлжсөн хуулийн аль аль талаас нь гагцхүү ОХУ-ын эрдэмтэн Т.В.Кашанина “Хууль зүйн техник” (*Юридическая техника*)<sup>7</sup> бүтээлдээ дурдсан байна.

Монгол Улсад хэрэглэгдэж буй хууль зүйн техникийн сурах бичиг, бүтээлийг үзвэл, эрх зүйн актын системчлэлийг кодификацаас тусад нь буюу “хууль тогтоомжийн системчлэл”-ийн үндсэн дөрвөн аргын нэг хэмээж, агуулгаар нь “Эрх зүйн актын бүртгэл буюу лавлагаа мэдээллийн сан бүрдүүлэх”<sup>8</sup> ажиллагаанд хамааруулжээ. Гэвч “... Эрх зүйн актын бүртгэл нь кодификаци, инкорпорацийн зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тэдгээрийн анхан шат хэмээн үзэж болно”<sup>9</sup> гэснээр кодификаци хэмээх өргөн ойлголтын нэг бүрдэл хэсэг нь эрх зүйн актын системчлэл мөн болохыг дүгнэж болно.

Түүнчлэн нэр томъёоны хувьд “кодификаци” гэвэл ихэвчлэн төрөлжсөн хууль буюу кодексийг ойлгох хандлага давамгайлах төдийгүй “эрх зүйн актын системчлэл”, “эрх зүйн актын ангилал”, “эрх зүйн актын бүртгэл” зэрэг олон янзаар бичигдэж байгаа тул хоёрдмол утга гаргахгүй байх үүднээс энэхүү судалгаанд “эрх зүйн актын системчлэл” гэсэн нэршлээр бичлээ.

Эрх зүйн актын системчлэлийг “... лавлагаа мэдээллийн ажил” хэмээн үзэж болно. Лавлагаа, мэдээллийн сан бүрдүүлэх арга ажиллагаа нь хууль тогтоомжийн системчлэлийн эхний шатны бааз суурь, тасралтгүй үргэлжилдэг ажил мөн.<sup>10</sup> Системчлэл нь хууль, эрх зүйн хэм хэмжээ бүхий актыг цуглуулах, тэдгээрийг тусгайлан батлагдсан ангиллын дагуу ангилан индексжүүлэн төрөлжүүлэх, төрөлжүүлсэн каталог, карт хөтлөх, механик буюу цахим тооцоолуурын автоматжуулсан сан бүрдүүлэх ажиллагаанаас бүрдэнэ. Лавлагаа, мэдээллийн санг:

- Үндэсний хууль тогтоомжийн;
- Шүүхийн шийдвэрийн;
- Захиргааны хэм хэмжээний актын;
- Олон Улсын гэрээ хэлэлцээрийн гэж ангилж болно.

Монгол Улсын хувьд хууль тогтоомжийг системчлэх ажил 1950-иад оны сүүлчээр эхэлж, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газарт Хууль цаазын хороо байгуулан ажиллуулсан түүхтэй. Системчлэлийн ажил 1921 оноос батлагдан гарсан бүх хууль тогтоомжийг хүчинтэй эсэхийг харгалзахгүйгээр худам монгол бичгээс кирилл үсэгт хуулбарлан буулгахаас гараагаа эхэлж, тэдгээрийг тусгайлан баталсан ангиллын дагуу улс

<sup>7</sup> Т.В.Кашанина, *Юридическая техника* (Москва: Норма-Инфра-М, 2011), с. 341-343.

<sup>8</sup> Д.Лүндээжанцан, *Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник* (УБ: ВСИ хэвлэл, 2016), 126 дахь тал.

<sup>9</sup> Мөн тэнд, 129 дэх тал.

<sup>10</sup> О.Амархүү, *Эрх зүйн онолын арван таван сэдэв* (УБ: Адмон хэвлэл, 2008), 61 дэх тал.

ардын аж ахуйн болон эрх зүйн салбараар төрөлжүүлэн лавлагаа, мэдээллийн санг картаар бүрдүүлсэн нөр их хөдөлмөрөөр бүртээгдэж байжээ.<sup>11</sup>

Дараа нь 1960-аад оны дунд үеэс инкорпорацийн аргаар он дарааллын системчилсэн эмхэтгэлүүдийг бэлтгэн хэвлүүлж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагын үүднээс системчлэлийн ажлыг улам нарийвчлан үргэлжлүүлэх Улсын комисс 1982 онд байгуулагдан ажиллажээ. Тэрхүү комисс хууль тогтоомжийн системчлэлийг инкорпорацийн болон кодификацийн аргаар хослуулан хийж, 1990 он хүртэлх хугацаанд төрийн байгуулалт, эдийн засаг, нийгэм, соёл, боловсрол зэрэг салбаруудаар төрөлжүүлсэн “БНМАУ-ын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн системчилсэн бүрэн эмхэтгэл долоон боть”-ийг хэвлүүлсэн<sup>12</sup> байна.

Тус долоон ботиос гадна Үндсэн хууль, засаг захиргаа, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, их барилга, тээвэр, холбоо, шинжлэх ухаан, ардын боловсрол, соёл гэгээрэл, эрүүлийг хамгаалах, батлан хамгаалах, хэв журмын, биеийн тамир спортын зэрэг нийгмийн харилцааны болон эрх зүйн зохих салбар, дэд салбараар ангилж эрэмбэлсэн олон зүйл эмхэтгэл гарган хэрэглэж ирсэн түүхтэй. Хууль зүйн үндэсний төв (тухайн үеийн нэршлээр) 2008 онд хүчин төгөлдөр хууль тогтоомжийн сугалбар хуудастай 4 боть эмхэтгэлийг “Монгол Улсын хууль” нэрээр хэвлэн гаргасан нь хэрэглээний талаасаа ихээхэн чухал дорвитой бүтээл болсон.<sup>13</sup>

## **2.2. Системчлэх арга, онцлог шинж, давуу тал**

Нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээдийн аль нь байхаас үл хамааран хууль дээдлэх ёсыг сахиж, хуульд нийцсэн үйл ажиллагаа явуулах үүрэгтэй бөгөөд “... эрх зүйг хэрэглэх үед хүчин төгөлдөр хууль тогтоомжийг л баримтлах учиртай. Иймээс үүнийг хэрэгжүүлэгч эрх бүхий албан тушаалтнууд хэрэглэх гэж байгаа хуулиа хүчин төгөлдөр эсэхийг сайн магадлан шалгаж хэрэглэх ёстой.”<sup>14</sup>

Эрх зүй бүтээх ажиллагааг хууль тогтоомжийн нарийвчилсан, бүрэн дүүрэн бүртгэлгүйгээр хэрэгжүүлэх боломжгүй юм. Хэрэв ийм бүртгэлгүй бол мэргэшлийн талаас чанартай сайн хууль боловсруулах, түүнд экспертиз хийх боломж хомс болно. Эрх зүйн актын бүртгэл хийхгүйгээр эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх боломжгүй. Өөрөөр хэлбэл, эрх зүйн актын бүртгэл нь эрх зүйн субъектуудын мэдээллийн хэрэгцээг хангах чиглэлээр үйлчилнэ.<sup>15</sup>

Эрх зүйн актын системчлэлийн төрөл, хэлбэр олон янз бөгөөд иж бүрэн /институтчилсэн, сэдэвчилсэн/, дагнасан, холимог, албан ёсны ба албан бус, мэргэжил-техникийн, шинжлэн боловсруулалтын, түүхчилсэн, хэсэгчилсэн, хэрэглээний, судалгааны

---

<sup>11</sup> Мөн тэнд, 62-63 дахь тал.

<sup>12</sup> Мөн тэнд.

<sup>13</sup> Б.Чимид “Хууль тогтоомжийг системчлэхэд Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэлийн онол, практикийн ач холбогдол” (УБ: 2010), <https://www.legalinfo.mn/details/535> хаягаас үзнэ үү.

<sup>14</sup> Д.Лүндээжанцан, *Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник* (УБ: ВСИ хэвлэл, 2016), 128 дахь тал.

<sup>15</sup> Мөн тэнд, 129 дэх тал.

гэхчлэн хамрах хүрээ, сэдэв, зорилго, зориулалт, хүчин чадал, ач холбогдлын хувьд олон хэлбэр дүрстэй.<sup>16</sup> Ерөнхийдөө эрх зүйн актын системчлэлийн дараах үндсэн хоёр төрөл байна:

- Албан ёсны: Албан ёсны бүртгэлийг төрийн байгууллагуудын хууль зүйн албад гүйцэтгэнэ.
- Албан бус: Улсын хэмжээний бүх актыг хамарсан бүртгэлийг тухайн байгууллага болон хувь хүн гүйцэтгэх боломжгүй тул өөрсдийн хэрэгцээнд нийцүүлэн бүртгэлийн ажлыг хэрэгжүүлнэ.

Түүнчлэн эрх зүйн актын системчлэлийн янз бүрийн арга байдгаас гол төлөв дараах аргуудыг хэрэглэдэг:

- Картжуулалт: Энэ нь эрх зүйн актын системчлэлийн хамгийн түгээмэл арга бөгөөд картуудыг тодорхой дэс дараалалд байрлуулан актыг баталсан байгууллага, нэр, баталсан огноо зэрэг мэдээллийг тусгадаг. Картжуулан оруулсан мэдээлэл актын талаар мэдлэг олж авахад тус дөхөм болох, шууд сонголт хийж авах боломжоор хангах, актыг буцааж хэвэнд нь оруулах, тэдгээрээс дахин шинэ эшлэл хийх зэргээр ашигладаг. Үүнтэй холбогдуулан дурдахад, төрийн захиргааны байгууллагуудад “кодификатор” гэх хууль, зарлиг гэхчлэнг зохих ангиллын дагуу шошголж /“карталж”/, “шивж” лавлагаа өгдөг орон тоо байдаг.<sup>17</sup>
- Эмхэтгэсэн хавтас: Энэ аргыг эрх зүйн актын тоо хэмжээ цөөхөн бол ашиглахад тохиромжтой. Энэ тохиолдолд актыг тодорхой дэс дараалалд оруулж тусгай хавтаст хийж ашиглана.
- Мэдээлэл хайлтын систем: Техник технологи хөгжиж, өдөр тутмын хэрэглээнд нэвтэрсэн өнөө үед дээрх аргууд хоцрогдож, эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем буюу эрх зүйн актын бүртгэлийг нэг дор цахим хэлбэрт оруулсан хувилбар түгээмэл ашиглагдаж байна.

Эрх зүйн актын системчлэлийн давуу талыг дараах байдлаар тодорхойлж болох юм.

Кодификаци байнга, тасралтгүй хийснээр:

- Хууль тогтоомж маш тодорхой, уялдаа холбоотой болдог;
- Хууль илүү энгийн, бүгдэд хүртээлтэй, ойлгогдох боломжтой болж, улмаар иргэд эрх, үүргээ сайтар ухамсарлан мэддэг;
- Хууль хооронд давхардал, хийдэл, зөрчилдөөн бага гардаг;
- Хуулийг тогтвортой<sup>18</sup> байлгадаг. Хуулийн тогтвортой байдал гэдэг тун чухал тул хуулийг хэрэглэх явцад эргэлзээ тээнэгэлзэл төрөх явдал багассанаар хууль хэрэглээ илүү хялбар болдог;
- Кодификаци нь нэгдмэл, өргөн хүрээний хэрэглээг нийгэмд авчирдаг тул улс орны хөгжил төлөвлөгөөний дагуу урагшилдаг.

<sup>16</sup> Б.Чимид “Хууль тогтоомжийг системчлэхэд Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэлийн онол, практикийн ач холбогдол” (УБ: 2010), <https://www.legalinfo.mn/details/535> хаягаас үзнэ үү.

<sup>17</sup> Мөн тэнд.

<sup>18</sup> Gunther A.Weiss “The Enchantment of Codification in the Common Law World” *Yale Journal of International Law* (2000) 8 (25): s.469.

## ГУРАВ. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нийгмийн хөгжлийн явцад хүмүүсийн хэлзүйн чадвар өсөн нэмэгдэж, хууль зүйн салбар дахь төрөл бүрийн ялгаатай нэр томъёог ойлгож, ялган зааглахад өөр өөр нэр томъёо ашиглах боломжтой болжээ. Энэ үүднээс хууль тогтоомжийн системчлэлийн бусад төрлүүдийг мөн “кодификаци” гэсэн нэг нэр томъёогоор илэрхийлэх шаардлагагүй болов уу. Иймд ямартай ч Оросын хууль зүйн шинжлэх ухаанд “кодификаци” гэсэн нэр томъёог онцгой утгаар хэрэглэх нь зүйтэй гэж зарим эрдэмтэд<sup>19</sup> нь үзэж байна. Энэ тухай тус судалгааны Хоёр дахь хэсгийн 2.1-д дурдсан тул үл нуршин Монгол Улсад өнөөдрийн байдлаар кодификацийн аргаар эрх зүйн актыг системчлэх үйл ажиллагаа ямар түвшинд байгааг авч үзье.

Эрх зүйн актын албан ёсны бүртгэлийг төрийн байгууллагуудын хууль зүйн албад гүйцэтгэх бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>20</sup> 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэгт “Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээлэл, лавлагаа өгөх зорилгоор Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн нэгдсэн санг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх, хууль тогтоомжийг системчлэх ажлыг хариуцан зохион байгуулна” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам эрх зүйн актын бүртгэлийг гардан хэрэгжүүлж байна.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэгт “... хууль тогтоомжийн сан бүрдүүлэх, системчлэн ангилж, хууль тогтоомжийн хувийн хэрэг хөтлөх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсний дагуу эрх зүйн актын системчлэл буюу кодификаци хийхэд баримталж буй дараах журам байгааг хүснэгт хэлбэрээр жагсаавал:

**Хүснэгт 1. Баримталж буй журмын жагсаалт**

Нэр	Дугаар	Батлагдсан огноо
“Эрх зүйн актын ангилагчийг батлах тухай” <sup>21</sup>	Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал №147	2003-08-15
<i>Нэмэлт тайлбар:</i> Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2017 оны Үр дүнгийн гэрээнд заасны дагуу Хууль тогтоомжийн ангилагчийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгээс хийж гүйцэтгэсэн ажлын тайлан болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 147 дугаар тушаалаар батлагдсан “Эрх зүйн актын ангилагч”-ийг шинэчлэн боловсронгуй болгох саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдөр 01/353 тоот албан бичгээр хүргүүлсэн.		
“Хууль тогтоомжийн сан бүрдүүлж, системчлэн ангилах журам”	Хууль зүйн сайдын тушаалын нэгдүгээр хавсралт А/221	2016-07-01

<sup>19</sup> Т.В.Кашанина, *Юридическая техника* (Москва: Норма-Инфра-М, 2011), с. 343.

<sup>20</sup> *Төрийн мэдээлэл эмхэтгэл* (2015), №25

<sup>21</sup> А.Түвшинтулга нар, *Хууль зүйн арга ажиллагаа /эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл/* (УБ: ХЗҮХ-гийн хэвлэх үйлдвэр, 2018), 247 дахь тал.

“Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам”	Хууль зүйн сайдын тушаалын нэгдүгээр хавсралт А/226	2016-07-01
“Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийг ажиллуулах журам”	Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайд, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга нарын хамтарсан тушаал, захирамжийн нэгдүгээр хавсралт 17/А/10/А/04/36/02/03/А/01	2017-01-16
“Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулах мэдээллийн төрөл, хугацаа, хариуцах байгууллага”	Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайд, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга нарын хамтарсан тушаал, захирамжийн хоёрдугаар хавсралт 17/А/10/А/04/36/02/03/А/01	2017-01-16
“Эрх зүйн актыг бүртгэх, эрх зүйн актын ангилагчийг ашиглаж системчилсэн картан сан, хяналтын хувийг хөтлөх аргачилсан зөвлөмж”	Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаал	2009-03-11

Эрх зүйн актыг системчлэхэд дээрх хүснэгтэд дурдсан баримт бичгүүдийг мөрдөж байгаа бөгөөд эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем болох [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) цахим хуудаст Монгол Улсын хэмжээнд батлагдсан бүхий л хууль тогтоомжийг, Хууль зүй, дотоод хэргийн яамны [www.mojha.gov.mn](http://www.mojha.gov.mn) цахим хуудаст захиргааны хэм хэмжээний актын жагсаалтыг тус тус нийтэлж байна. Харин УИХ-д өргөн мэдүүлсэн болон олон нийтээр хэлэлцүүлж буй хуулийн төслүүдийг [www.mojha.gov.mn](http://www.mojha.gov.mn), <http://forum.parliament.mn/> цахим хуудсуудад тус тус нээлттэй байршуулж байгаа бол Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан болох [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) цахим хуудаст Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэрүүдийг нийтэлж байна.

Үүнээс үзэхэд манай улсын хувьд өмнөх хэсэгт дурдсанчлан, эрх зүйн актыг системчлэх бусад аргууд төдийлөн хэрэглэгдэхээ больж, улмаар эрх зүйн мэдээллийн нэгдсэн цахим системийг ашиглах болжээ гэж үзэж болохоор байна. Иймд цаашид цахим хуудас ашиглан эрх зүйн актыг системчлэх ажлыг цаашид улам боловсронгуй болгох талаар анхаарах шаардлагатай.

## **ДӨРӨВ. ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА**

Гадаад улсын эрх зүйн шийдлийг хүлээн авахын тулд, нэгдүгээрт, эрх зүйн хэм хэмжээ нь “экспортолж” буй улсдаа хэрэгжих боломжтой, шударга ёсыг хангасан гэдэг нь нотлогдсон эсэх, хоёрдугаарт, хүлээн авах гэж байгаа улсын нөхцөл, эрх зүйн тогтолцоонд үйлчлэх боломжтой эсэхийг судлах ёстой байдаг.<sup>22</sup> Түүнчлэн харьцуулсан судалгааны объектыг “харьцуулж болохуйц” эсэхийг<sup>23</sup> судалсны үндсэн дээр сонгох учиртай.

Эрх зүйн актын системчлэл буюу кодификаци, тэр дундаа эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем бий болгох, хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах цахим систем бүтээх ажиллагаа нь эрх зүйн бүлээс үл хамааран улс бүрт байх тогтолцоо тул энэ хэсэгт эрх зүйн бүлийг харгалзахгүйгээр эрх зүйн актын системчлэлийн цогц, бүрэн цахим систем бүхий улсуудын туршлагыг судаллаа.

### **4.1. Америкийн Нэгдсэн Улс (АНУ)**

#### 4.1.1. Эрх зүйн актын нэгдсэн сан:

АНУ дахь эрх зүйн актын нэгдсэн санг албан ёсны болон албан ёсны бус гэж хоёр ангилж болох юм. Учир нь хууль тогтоомжийг албан ёсоор нийтэлдэг цахим хуудсаас гадна хувь хүн, хуулийн этгээдэд тухайн хуулийг хэрэглэхэд дөхөм болох зорилгоор хялбар шийдэлтэй бүтээгдсэн албан бус цахим хуудсууд байдаг.

АНУ-ын Холбооны бүх хууль тогтоомжийн нэгдсэн албан ёсны цахим хуудас нь [www.congress.gov](http://www.congress.gov) болон [www.govinfo.gov](http://www.govinfo.gov) юм. Эдгээр хуудсуудад нийтлэгдсэн хууль тогтоомжийг гуравдагч хэрэглэгчдэд илүү ойлгомжтой байдлаар <http://www.loc.gov/law/help/guide.php> хуудаснаас үзэж болно. Түүнчлэн мужууд нь дотоодын хууль тогтоомжийг нийтэлдэг тус тусын цахим хуудастай бөгөөд тэдгээрийг <https://www.congress.gov/state-legislature-websites> хуудсанд байршуулдаг.

Тус улсын хууль тогтоомжийг дотор нь “Хувийн”, “Нийтийн” гэж ангилах бөгөөд хэддүгээр Конгрессийн үед батлагдсанаар нь эрэмбэлэн нэрлэсэн байна. Тухайлбал, Public Law 107-101 гэвэл 107 дугаар Конгрессийн үед батлагдсан, 101 дүгээр Нийтийн эрх зүйн хууль гэж ойлгоно. Хувийн эрх зүйн хуулийн хувьд дугаарлалт адил, гагцхүү Private Law гэсэн нэршил урд нь бичигддэг.

Мөн тус улсын ихэнх хуулиудад кодификаци хийж, нэгтгэдэг бөгөөд тэдгээр нь тогтмол 54 бүлгээс бүрддэг боловч 6 жил тутамд шинээр батлагдсан хуулиудыг АНУ-ын

<sup>22</sup> Б.Амарсанаа, *Харьцуулсан эрх зүй судлал*, 2 дахь хэвлэл (УБ: МУИС Пресс, 2014), 29 дэх тал.

<sup>23</sup> UvA, Amsterdam Law School, *Thesis Manual* (Amsterdam: University of Amsterdam, 2005), p.17.

Засгийн газрын Хэвлэлийн газар /Government Publishing Office (GPO)/ хэмээх АНУ-ын хууль тогтоох байгууллагын харьяа агентлагаас тохирох бүлэг, ангилал тус бүрд шинээр нэмж, эмхэтгэсэн хувилбарыг хэвлэн нийтэлдэг. Эдгээрийг <http://uscode.house.gov/browse.xhtml> цахим хуудаст тухай бүрд нь байршуулдаг.

Дээр дурдсан хуудсуудад хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг нэн даруй оруулах, хууль тогтоомж хоорондын уялдаа холбоог хангах тал дээр онцгой анхаардаг. Түүнчлэн бүх хууль тогтоомжийг бус шүүхийн практикт бодит гардаг хэрэг маргаантай холбогдолтой, өдөр тутмын эрх зүйн харилцаанд түгээмэл хэрэглэгддэг хуулиудын талаар хувь хүн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөх зорилго бүхий <https://www.alllaw.com/>, <https://statelaws.findlaw.com/> зэрэг цахим хуудсууд ажилладаг.

АНУ-ын эрх зүйн актын нэгдсэн сангийн хайлтын системийн давуу тал нь:

- үсгийн дарааллаар (англи хэлний A-Z үсэг хүртэлх дарааллаар);
- ангилал/категориор (хуулийн төсөл, хувийн буюу нийтийн эрх зүйн хууль, эрх зүйн бусад акт, төрөлжсөн хууль);
- огноогоор;
- хороогоор (Нийтийн танхим болон Сенатад харьяалагддаг олон салбар хороодын чухам аль хороонд хамааралтай хууль тогтоомж болох);
- зохиогчоор (Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх эрх мэдлийн аль байгууллагад хамаарах буюу төсөл боловсруулсан агентлагаар) зэрэг олон сонголттой хайлт хийдэгт оршино.

#### 4.1.2. Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах цахим систем:

АНУ-ын хэмжээнд батлагдаж буй 1973 оноос хойших бүх хуулийн төсөл, тэдгээрийн хэлэлцэж байгаа байдал, хууль бүтээх үйл явц зэргийг [www.congress.gov](http://www.congress.gov) цахим хуудаст байршуулдаг.

Тус улсад “танилцуулах-Сенат батлах-Нийтийн танхим батлах-Өөрчлөлт, засварыг шийдвэрлэх-Ерөнхийлөгчид хүргүүлэх” гэсэн дарааллаар хууль бий болдог. Сенат болон Нийтийн танхим тухайн хуулийн төслийг дэмжсэний дараа Ерөнхийлөгч гарын үсгээ зурж, баталгаажуулснаар хууль батлагдах бөгөөд түүнийг “Конгрессийн хууль” гэж нэрлэнэ. Ерөнхийлөгч хуульд гарын үсэг зурмагц хуулийг гарын үсэг зурсан дарааллаар дугаарлана. Дээр дурдсанчлан, P.L.107-101 зэрэг.

Ингэхдээ хууль батлагдах үйл явц, нэмэлт, өөрчлөлт, хурлын тэмдэглэл, тайлан зэрэг бүх баримт бичгийг тухай бүрд нь огноотой нь дэлгэрэнгүй байдлаар цахим хуудаст байршуулдаг. Жишээлбэл, нэг хуулийн төслийг санамсаргүй түүврийн аргаар сонгож, зургаар үзүүлье.

***Зураг 1. АНУ дахь хууль боловсруулах үйл явц цахим хуудаст харагдах байдал***



All Legislation

Examples: hr5, sres9, "health care"



MORE OPTIONS

[Home](#) > [Legislation](#) > [115th Congress](#) > S.3021[Print](#) [Subscribe](#) [Share/Save](#) [Give Feedback](#)**S.3021 - America's Water Infrastructure Act of 2018**

115th Congress (2017-2018)

**LAW**

Hide Overview

**Sponsor:** [Sen. Klobuchar, Amy \[D-MN\]](#) (Introduced 06/07/2018)

**Committees:** Senate - Environment and Public Works | House - Transportation and Infrastructure

**Latest Action:** 10/23/2018 Became Public Law No: 115-270. ([All Actions](#))

**Roll Call Votes:** There have been [2 roll call votes](#)

**Tracker:**[Introduced](#) > [Passed Senate](#) > [Passed House](#) > [Resolving Differences](#) > [To President](#) > [Became Law](#)

More on This Bill

[CBO Cost Estimates \[1\]](#)

Subject — Policy Area:

Water Resources Development

[View subjects >](#)

Summary (3)

Text (6)

Actions (48)

Titles (9)

Amendments (5)

Cosponsors (1)

Committees (2)

Related Bills (19)

Зургаас үзвэл 115 дахь Конгресс буюу 2017-2018 оны хооронд батлагдсан “Амеркийн Усны Дэд бүтцийн тухай хууль” байх бөгөөд 2018 оны 6 дугаар сарын 7-ны өдөр анх танилцуулж, хамгийн сүүлд 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдөр “Нийтийн эрх зүйн хууль” болжээ. “Tracker” буюу үйл явцыг харвал хууль боловсруулах 6 үе шатны хамгийн сүүлчийн алхам болох “Хууль батлагдсан” төлөвт байна. Тодруулбал, хуулийн төсөл хэлэлцэж батлах үйл явц (шууд танилцуулах үе шатаас эхэлж байх тул боловсруулах үе шат хамаарахгүй байна) дунджаар 4 сарын турш үргэлжилжээ.

Түүнчлэн хуудасны доод хэсэгт “Хураангуй”, “Хуулийн бичвэр”, “Үйлдэл” (төсөл батлах явцыг огноотой нь дэлгэрэнгүй оруулсан байх бөгөөд тус хуульд нийт 48 удаагийн үйлдэл хийгдсэн байна), “Нэр” (төсөл байх хугацаанд хуулийг хэрхэн нэрлэх талаарх саналуудыг оруулсан бөгөөд тус хуулийн хувьд анх “Усны нөөцийг боловсронгуй болгох тухай” гэсэн нэртэй байсан байна), “Нэмэлт, өөрчлөлт”, “Хамтран санаачлагч” (тус хэсэгт дарвал хуулийн төслийн санаачлагч болон хамтран санаачилсан сенаторын нэр байх бөгөөд энэхүү хуулийн хувьд санаачлагч 1, хамтран санаачлагч 1, нийт 2 сенатор санаачилжээ), “Хороод” (хуулийн төсөлд хамаарах хороод), “Холбоотой төсөл” (санаачлагч, журам, бичвэр зэргээрээ адил төстэй байж болох бусад хуулийн төслүүд) гэсэн булангууд тус тус байна.

Нэмж дурдвал, АНУ-д боловсруулсан бэлэн хуулийн төслийг засварлах, кодчилох, техник талаас нь хянах чиг үүрэг бүхий Open Law Library<sup>24</sup> нэртэй цахим хуудас ажилладаг байна. Өөрөөр хэлбэл, боловсруулсан төслөө хянах гэж олон сарын хугацаа алдалгүйгээр тус байгууллагад хандан техник ажиллагаатай холбоотой бусад зүйлсийг хийлгэх боломжтой. Гэсэн хэдий ч, Конгрессийн түвшинд баталдаг холбооны хуулиудыг ийнхүү хянуулах боломжгүй бөгөөд гол төлөв мужийн түвшинд баталдаг хууль тогтоомжид

<sup>24</sup> <http://www.openlawlib.org/platform/open-law-codify/> хаягаас дэлгэрэнгүйг үзнэ үү.

кодификаци хийсэн байна. Гэвч ингэхдээ холбооны хуулиас мужид хамааралтай зохицуулалтыг мужийн хуульд нэгтгэж, системчилж болохоор ажээ.

Мөн түүнчлэн дээрхтэй адил чиг үүрэгтэй Municode<sup>25</sup> хэмээх цахим хуудас ажилладаг ба мэргэжлийн өмгөөлөгчдийн тусламжтайгаар муж, тэр дундаа хотуудын хууль тогтоомжийг нэгтгэх, системчлэх ажиллагаа хийдэг. Хэдийгээр эдгээр цахим хуудсууд нь Конгрессийн цахим хуудас, хууль батлах ажиллагаатай харьцуулбал харьцангуй хялбар, хурдан боловч ажиллагааг автомат цахим хэрэглүүрээр бус хувь хүн, баг хамт олон хийдэг гэдгийг анхаарах шаардлагатай. Түүнээс гадна, эдгээр нь албан ёсны төрийн захиргааны байгууллага биш тул ийм төрлийн систем Монгол Улсад төдийлөн тохиромжтой биш юм. Харин одоо байгаа цахим хуудсуудаа Конгрессийн хууль тогтоомжийн төслийн албан ёсны цахим хуудас шиг илүү боловсронгуй болгож сайжруулах нь оновчтой арга байж болох юм.

## **4.2. ХБНГУ (Холбооны Бүгд Найрамдах Герман Улс)**

### 4.2.1. Эрх зүйн актын нэгдсэн сан:

ХБНГУ-ын хууль тогтоомжийн нэгдсэн сангийн албан ёсны цахим хуудас нь ХБНГУ-ын Эрх зүйн мэдээллийн систем - <https://www.gesetze-im-internet.de/index.html> болно. Энд Холбооны хуулийн эмхэтгэлд нийтлэгдсэн хуулиудын цахим хувилбар байх бөгөөд хуулийн тайлбар, хуулийн албан ёсны орчуулсан хувилбар байршдаг. Түүнчлэн мужийн хууль тогтоомжийг <https://justiz.de/bundlaender/index.php> цахим хуудаснаас муж тус бүрийн нэр бүхий холбоос дээр даран үзэх боломжтой.

Холбооны Үндсэн хуулийн шүүх, Эрүүгийн хэргийн шүүх, Захиргааны хэргийн шүүх, Татварын шүүх, Хөдөлмөрийн шүүх, Дээд шүүх зэрэг Холбооны шүүхийн шийдвэрүүдийг <https://www.rechtsprechung-im-internet.de> цахим хуудаст; Холбооны Засгийн газрын яамдын захиргааны хэм хэмжээний актыг <http://www.verwaltungsvorschriften-im-internet.de> цахим хуудаст тус тус байршуулдаг байна. Мөн Холбооны хуулийн эмхэтгэл (Bundesgesetzblatt)-ийг хэвлэгдсэн даруйд нь эмхэтгэл хэлбэрээр нь <https://www.bgbl.de/> цахим хуудаст байршуулдаг.

Ингэхдээ дээр дурдсан хуудас бүрт байрших хууль тогтоомжийг татаж авах хувилбар нь сонголттой байдагт эдгээрийн давуу тал оршино. Хууль тогтоомжийг үсгийн дараалал болон дугаараар эрэмбэлсэн байгаа нь Монгол Улсад хэрэглэгдэж буй [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) цахим хуудастай ижил төстэй боловч бүх хууль тогтоомж, шүүхийн шийдвэр, захиргааны хэм хэмжээний акт, хуулийн эмхэтгэлийг HTML, PDF, XML, EPUB гэсэн өргөтгөлөөс сонгон үзэх, татаж авах боломжтой байршсанаар илүү дэвшилттэй байна.

Хэдийгээр хууль тогтоомж, шүүхийн шийдвэр зэргийг өөр өөр цахим хуудаст байршуулж буй боловч эдгээрийн загвар, бүтэц, татаж авах хувилбар, хайлтын горим зэрэг нь яг адил учраас нэгдмэл, бүрэн цогц систем гэж үзэж болохоор байна.

---

<sup>25</sup> <https://www.municode.com/codification-and-recodification/#footer> хаягаас дэлгэрэнгүйг үзнэ үү.

#### 4.2.2. Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах цахим систем:

ХБНГУ-ын хууль боловсруулах, батлах үйл явцын талаар мэдээлэл Бундесрат<sup>26</sup> болон Бундестагийн<sup>27</sup> албан ёсны цахим хуудаст ил тод, хангалттай байх боловч хууль тогтоомжийн төслийг байршуулаагүй байна.

Өмнөх хэсэгт дурдсан хууль тогтоомжийн албан ёсны цахим хуудас болох <https://www.gesetze-im-internet.de/index.html> хуудаст гагцхүү батлагдан гарсан хууль тогтоомжууд байх бөгөөд эрх зүйн актын нэгдсэн санг маш сайн хөгжүүлсэн хэдий ч хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах цахим системийг хөгжүүлээгүй байна. Өөрөөр хэлбэл, хууль тогтоох үйл явцаас илүү батлагдсан хуулийг сурталчлах ажиллагаанд чухал ач холбогдол өгдөгтэй холбон ойлгож болох юм.

### **4.3. ОХУ (Оросын Холбооны Улс)**

#### 4.3.1. Эрх зүйн актын нэгдсэн сан:

Төрийн эрх мэдлийн холбооны улсын хэмжээний байгууллага бүрт эрх зүйн мэдээллийн мэдээлэл хайлтын автоматжуулсан систем байна.<sup>28</sup> Үүнээс гадна хувийн мэдээлэл хайлтын системүүд өргөн дэлгэр хөгжиж байгаа билээ. Жишээлбэл, “КонсультантПлюс”<sup>29</sup>, “Гарант”<sup>30</sup>, “Кодекс”<sup>31</sup> зэрэг нь зүгээр нэг эрх зүйн актын цахим карт биш юм.

Мэдээлэл хайлтын системийн онцлог давуу талыг<sup>32</sup> товч дурдвал:

- Мэдээлэл хайлтын систем нь сонирхож буй эрх зүйн тулгамдсан асуудлаар бүрэн хэмжээний мэдээлэл олж авах бололцоогоор хангана. Тухайлбал, мэдээлэл хайлтын систем болох “КонсультантПлюс”-ын мэдээллийн сан 1,5 сая баримт бичгээс бүрдэх бөгөөд эрх зүйн актын бүх төрөл, бүх түвшинг (Холбоо, Мужийн хэмжээний) хамаарна.
- Мэдээлэл хайлтын системийн мэдээллийн сан нь байнга нэмэгдэн баяжиж өөрчлөгддөг бөгөөд эрх зүйн актуудын нэмэлт, өөрчлөлт орсон болон шинэчлэн найруулсан хувилбарыг байршуулдаг.
- Мэдээлэл хайлтын систем нь мэдээллийн сан дахь баримт бичиг хоорондын уялдаа холбоог харахад тусалдаг.
- Сэдэвчилсэн сонголт буюу нарийвчилсан хайлт хийх боломжтой тул хэрэгтэй эрх зүйн актаа богино хугацаанд олдог.

#### 4.3.2. Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах цахим систем:

<sup>26</sup> <https://www.bundesrat.de> хаягаас үзнэ үү.

<sup>27</sup> <https://www.bundestag.de> хаягаас үзнэ үү.

<sup>28</sup> Т.В.Кашанина, *Юридическая техника* (Москва: Норма-Инфра-М, 2011), с. 365.

<sup>29</sup> <http://www.consultant.ru/> хаягаас үзнэ үү.

<sup>30</sup> <http://www.garant.ru/> хаягаас үзнэ үү.

<sup>31</sup> <https://kodeks.ru/> хаягаас үзнэ үү.

<sup>32</sup> Т.В.Кашанина, *Юридическая техника* (Москва: Норма-Инфра-М, 2011), с. 365-366.

Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах цахим системийн хувьд ОХУ-ын загвар нэлээд боловсронгуй, дэвшилттэй юм. ОХУ-ын Төрийн Думын хууль тогтоомжийн мэдээллийн албан ёсны цахим хуудас болох <http://sozd.duma.gov.ru/> хуудаст бүх хуулийн төслийг хэлэлцэх үйл явцын хамт дэлгэрэнгүй байдлаар байршуулсан байдаг. Тус цахим хуудас нь АНУ-ын Конгрессийн хуулийн төслийн цахим хуудастай нэлээд төстэй төдийгүй түүнээс дэвшилтэт, ойлгомжтой гэж хэлж болно.

Тус цахим хуудас руу зочлоход нүүр хуудас хэсэгт “Хуулийн төсөл”, “Хуулийн төсөл хэлэлцэх үе шат”, “Хуулийн төсөлтэй холбогдох уулзалт, төлөвлөх баримт бичгүүд” гэсэн булангууд байна. Жишээлбэл, нэг хуулийн төслийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч зураг хэлбэрээр үзүүлбэл:

**Зураг 2. ОХУ дахь хууль боловсруулах үйл явц цахим хуудаст харагдах байдал**

The screenshot shows the website 'Система обеспечения законодательной деятельности' (System of ensuring legislative activity). The main navigation bar includes 'ОБЪЕКТЫ ЗАКОНОТВОРЧЕСТВА' (Legislative Objects) and 'ДОКУМЕНТЫ' (Documents). The search results section is titled 'Результаты поиска (6382)' (Search Results (6382)) and shows a filter for 'В архиве шестого созыва: 6382' (In the 6th session archive: 6382). A specific bill is highlighted with the registration number '1039149-6' and the status 'В архиве' (In archive). The bill is titled 'О внесении изменений в Федеральный закон "О противодействии терроризму" и отдельные законодательные акты Российской Федерации в части установления дополнительных мер противодействия терроризму и обеспечения общественной безопасности' (On amendments to the Federal Law "On Counterterrorism" and other legislative acts of the Russian Federation in the part of establishing additional measures of counterterrorism and ensuring public safety). The bill was registered on 07.04.2016 and published on 07.07.2016.

Юун түрүүнд хайлт хэсгээс сонирхож буй хуулийн төслөө хайна. Бүртгэлийн дугаар, нэр, явц, хэлэлцүүлэгт танилцуулсан байдал, бүртгэсэн огноо зэрэг шалгуураас өөрийн сонирхож буй мэдээлэлд тулгуурлан хүссэн мэдээллээ хайж болно. Тухайлбал, зурагт үзүүлснээр 6 дахь удаагийн хэлэлцүүлгийн үе шатыг дамжсан хуулийн төслийг хайхад нийт 6382 хайлтын илэрц гарч иржээ.


Жишээ болгон сонгосон хуулийн төсөл нь “Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл байна.

**Зураг 3. “Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн харагдах байдал**

Законопроект  
№ 1092053-6 В архиве

О внесении изменений в Закон Российской Федерации «О средствах массовой информации» и статьи 5 и 38 Федерального закона «О рекламе»  
(в части исследования объема зрительской аудитории телеканалов)

Паспортные данные ↗


Субъект права законодательной инициативы	Депутат Государственной Думы А.К.Луговой
Форма законопроекта	Федеральный закон
Ответственный комитет	Комитет Государственной Думы по информационной политике, информационным технологиям и связи
Отрасль законодательства	120.050.000 Средства массовой информации
Тематический блок законопроектов	Экономическая политика
Профильный комитет	Комитет Государственной Думы по информационной политике, информационным технологиям и связи
Предмет ведения	Ведение РФ
Пакет документов при внесении	

СТАДИИ РАССМОТРЕНИЯ



Дээрх зургаас үзвэл, “Хууль санаачлагч”, “Хуулийн төслийн хэлбэр”, “Хариуцах хороо” (манай тохиолдолд “Мэдээллийн бодлого, мэдээллийн технологи, харилцаа холбооны Төрийн Думын байнгын хороо” байна), “Хууль тогтоомжийн ангилал” (120.050.000 Мэдээллийн хэрэгсэл), “Хуулийн төслийн сэдэвчилсэн ангилал” (эдийн засгийн бодлого), “Гол агуулга” (“Радио давтамжийн системийг хөгжүүлэх”), “Хууль боловсруулах үеийн бичвэр” зэрэг мэдээлэл байна.

**Зураг 4. “Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн үйл явц**





ЗАКОНОПРОЕКТ №1092053-6  [наверх](#)

[ЭРК ПО СОБЫТИЯМ](#) [ЭРК ПО ХРОНОЛОГИИ](#) [ОТЗЫВЫ](#) [ВИДЕОЗАПИСИ](#) [СТЕНОГРАММЫ ОБСУЖДЕНИЙ](#) [ГОЛОСОВАНИЯ](#)

**ВНЕСЕНИЕ ЗАКОНОПРОЕКТА В ГОСУДАРСТВЕННУЮ ДУМУ**

**Регистрация законопроекта и материалов к нему в САДД ГД**

06.06.2016 15:43

- зарегистрирован и направлен Председателю Государственной Думы
-  Текст внесенного законопроекта (Комитет Государственной Думы по информационной политике, информационным технологиям и связи)
-  Перечень актов федерального законодательства, подлежащих признанию утратившими силу, приостановлению, изменению, дополнению или принятию в связи с принятием данного закона (Комитет Государственной Думы по информационной политике, информационным технологиям и связи)
-  Финансово-экономическое обоснование (Комитет Государственной Думы по информационной политике, информационным технологиям и связи)
-  Сопроводительное письмо (Комитет Государственной Думы по информационной политике, информационным технологиям и связи)

[Показать еще 2](#)

**Прохождение законопроекта у Председателя Государственной Думы**




07.06.2016 16:46

направлен в комитет(ы) Государственной Думы (Комитет Государственной Думы по информационной политике, информационным технологиям и связи)

**ПРЕДВАРИТЕЛЬНОЕ РАССМОТРЕНИЕ ЗАКОНОПРОЕКТА, ВНЕСЕННОГО В ГОСУДАРСТВЕННУЮ ДУМУ**

**Принятие профильным комитетом решения о представлении законопроекта в Совет Государственной Думы**

08.06.2016

- предложить принять законопроект к рассмотрению (Предлагаемый срок представления отзывов, предложений и замечаний в комитет 10.06.2016) **10 п.7**
-  Проект решения Совета Государственной Думы (Комитет Государственной Думы по информационной политике, информационным технологиям и связи)
-  Письмо в Совет ГД (Комитет Государственной Думы по информационной политике, информационным технологиям и связи)
-  Решение комитета (Комитет Государственной Думы по информационной политике, информационным технологиям и связи)

Дээрх зурагт хуулийн төсөл хэлэлцэх, батлах үйл явцыг дэлгэрэнгүй өгүүлсэн байх бөгөөд тухай бүрийн эрх зүйн баримт бичиг, тэмдэглэл, дүрс бичлэгийг хавсаргасан байна.

### **Зураг 5. “Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг дэмжсэн эсэх үзүүлэлт**

ЭРК ПО СОБЫТИЯМ	ЭРК ПО ХРОНОЛОГИИ	ОТЗЫВЫ	ВИДЕОЗАПИСИ	СТЕНОГРАММЫ ОБСУЖДЕНИЙ	ГОЛОСОВАНИЯ
<b>22.06.2016</b> ▾					
16:50:14	(3 чтение) О проекте федерального закона № 1092053-6 "О внесении изменений в Закон Российской Федерации "О средствах массовой информации" и статьи 5 и 38 Федерального закона "О рекламе" (в части исследования объема зрительской аудитории телеканалов)				<b>Принят</b> За: 424 Против: 2 Воздержалось: 0
16:49:55	(второе чтение) О проекте федерального закона № 1092053-6 "О внесении изменений в Закон Российской Федерации "О средствах массовой информации" и статьи 5 и 38 Федерального закона "О рекламе" (в части исследования объема зрительской аудитории телеканалов)				<b>Принят</b> За: 431 Против: 2 Воздержалось: 0
13:38:36	(2 чтение таб. 1 принятые поправки) О проекте федерального закона № 1092053-6 "О внесении изменений в Закон Российской Федерации "О средствах массовой информации" и статьи 5 и 38 Федерального закона "О рекламе" (в части исследования объема зрительской аудитории телеканалов)				<b>Принят</b> За: 282 Против: 0 Воздержалось: 0
<b>15.06.2016</b> ▾					
15:42:50	(первое чтение) О проекте федерального закона № 1092053-6 "О внесении изменений в Закон Российской Федерации "О средствах массовой информации" и Федеральный закон "О рекламе" (в части исследования объема зрительской аудитории телеканалов)				<b>Принят</b> За: 435 Против: 0 Воздержалось: 0

ОХУ-ын Төрийн Думын гишүүдээс тухайн хэлэлцүүлж буй хуулийн төслийг дэмжсэн буюу дэмжээгүй тоог нарийвчлан гаргажээ.

Энэ маягаар ОХУ-д хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах ажиллагаа ил тод, ойлгомжтой, хүртээмжтэй, дэлгэрэнгүй байдлаар хийгдэж байна.

### **ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ**

Кодификаци гэсэн ойлголт нь нэлээд өргөн хүрээний ойлголт бөгөөд өнөөдрийг хүртэл тус ойлголтыг явцуу, уламжлалт утгаар нь буюу төрөлжсөн хууль (кодекс)-ийн талаас нь тайлбарлаж, ойлгож иржээ. Гэтэл орчин үеийн эрх зүйн хувьд кодификацийг өргөн утгаар нь тайлбарлах шаардлага бий болж байгаа буюу эрх зүйн актын системчлэлийн талаас нь дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай байна. Иймд энэхүү судалгаанд тэрхүү өргөн утга, агуулга бүхий ойлголтын нэг хэсэг болох эрх зүйн актын системчлэл талаас нь судаллаа.

Эрх зүйн актын системчлэлийн гол зорилго нь хууль хоорондын уялдаа холбоог хангах, зөрчил, давхардал, хийдлийг арилгах юм. Эрх зүйн актын системчлэлийн олон төрлийн арга хэлбэр байдгаас техник технологи эрчимтэй хөгжиж буй өнөө үед улсууд “Эрх зүйн актын мэдээллийн сан”-г цахим хэлбэрээр боловсруулан ашиглах болжээ. Мөн түүнчлэн хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах ажиллагааг цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх болсон байна. Ингэснээр хууль тогтоомжтой холбогдсон



мэдээллийн ашиглалтыг хялбаршуулах, үр ашгийг нь дээшлүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой.

Монгол Улсын хувьд эрх зүйн актын нэгдсэн санг [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) албан ёсны цахим хуудсаар нэгтгэж, системчилсэн төдийгүй хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх ажиллагааг Улсын Их Хурлын цахим хэлэлцүүлэг болох [www.forum.parliament.mn](http://www.forum.parliament.mn), Хууль зүй, дотоод хэргийн яамны [www.mojha.gov.mn](http://www.mojha.gov.mn) цахим хуудсуудаар тус тус нийтлэн хүргэж байна.

Энэхүү судалгааны “Гадаад орны туршлага” хэмээх дөрөв дэх хэсэгт эрх зүйн актын нэгдсэн сан болон хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх цахим системийг боловсронгуй байдлаар ашиглаж буй 3 улс болох АНУ, ХБНГУ, ОХУ-ыг сонгон авч судлав. Хэдийгээр эдгээр гурван улс нь гурвуулаа холбооны улс боловч дурдсан агуулгын хүрээнд эрх зүйн бүл, төрийн дэглэм харгалзахгүйгээр зөвхөн сайн туршлагыг судлах нь илүү хэрэгцээ, шаардлагатай байх тул ийн сонгон авсан билээ.

Дээрх 3 улсын туршлагаас харахад эрх зүйн актын системчлэлийг эрх зүйн актын нэгдсэн цахим сан боловсруулах замаар хөгжүүлж, хууль хоорондын уялдаа холбоог нарийн хангаж байна. Түүнчлэн хуулийн төсөл боловсруулахаас батлагдан гарах хүртэлх явцыг албан ёсны цахим хуудаст ил тод, дэлгэрэнгүй байршуулж байгаа нь сайн хууль батлагдах нэг үндэс гэж үзэж болно.

АНУ-ын хувьд батлагдсан хууль тогтоомж болон хэлэлцүүлгийн шатанд буй хуулийн төслүүдийг Конгрессийн цахим хуудаст нэгтгэн байршуулж, тус бүрт нь ойлгомжтой хайлтын систем, дэлгэрэнгүй зохицуулалтыг бий болгосноор хэрэглэгчдэд нэг дороос тухайн хууль тогтоомжийн цогц мэдээллийг авах боломжийг олгож байна.

ХБНГУ-ын хууль тогтоомж, тэдгээрийн тайлбар, орчуулга, шүүхийн шийдвэр, Холбооны хуулийн эмхэтгэл зэрэг нь тусдаа цахим хуудсуудад байршдаг боловч хэлбэрийн хувьд цахим хуудас бүрийн загвар, бүтэц, өнгө төрх адил тул нэгдсэн цогц систем гэж ойлгож болохоор ба тус бүрийн нүүр хуудасны зүүн талд бусад холбоосууд эмх цэгцтэй байрладаг тул хэрэглэгчид мөн л өөрийн сонирхсон мэдээллийг нэг дороос төвөггүй авах боломжтой. Харин хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх талаарх цахим хуудсыг хөгжүүлээгүй нь олон нийтэд батлагдсан хуулийг сурталчлах, тэдгээрийн уялдаа холбоог хангахад илүү ач холбогдол өгдөг гэж үзэж болохоор байна.

ОХУ-д эрх зүйн актын нэгдсэн сан болон хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх цахим хуудсууд тусдаа буюу хуулийн төслийг хууль тогтоох байгууллага болох Төрийн Думын хуудаст байршуулсан байдаг хэдий ч цахим хуудас хоорондын уялдаа холбоог сайн хангасан тул хэрэглэгчдэд чирэгдэл төвөг учрахааргүй байна. Хууль тогтоомж болон хуулийн төслийг өөр өөр цахим хуудаст байршуулдгаараа манай улстай адил боловч цахим хуудсуудын загвар, бүтэц, агуулгын хувьд илүү ойлгомжтой, дэлгэрэнгүй, мэдээллүүдийг цаг алдалгүй оруулдаг, үе шат тус бүрийг нарийвчлан тайлагнадгаараа давуу талтай байна.

Иймд судалгааны хүрээнд хийсэн дүгнэлтийг үндэслэн дараах саналыг гаргаж байна. Үүнд:

1. *Эрх зүйн актын нэгдсэн санг боловсронгуй болгох үүднээс:*

- Өнөөдрийн байдлаар эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем дэх хууль тогтоомжийг гагцхүү үсгийн дараалал, огноо зэрэг хэлбэрийн шалгуураар ангилж буй бөгөөд цаашид зохицуулж буй харилцаагаар нарийвчлан ангилан системчлэх нь оновчтой.
- Салбар хуулиудын захиргааны хэм хэмжээний акттай холбогдох уялдаа холбоог хангах шаардлагатай. Тухайлбал, Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Хууль зүйн хэлний салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэсний дагуу баталсан журмыг хуулийн зүйл, заалттай холбож өгөх. Ингэснээр салбарын хууль болон захиргааны хэм хэмжээний актын уялдаа холбоо нэлээд хангагдах юм.
- Хуульд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй зохицуулалт байвал тухайн заалт дээр дарахад Үндсэн хуулийн цэцийн холбогдох дүгнэлт рүү шууд ордог /холбоосоор/ байдлаар холбох шаардлагатай бөгөөд ингэснээр хууль хэрэглээ илүү дөхөм болно.
- Хуулийн нэмэлт, өөрчлөлт орсон зохицуулалт нь тухайн хуулийн талаарх чухал мэдээллийг агуулдаг тул “нэмэлт, өөрчлөлт оруулсан” гэх өгүүлбэр дээр дарахад нэмэлт, өөрчлөлт орохоос өмнөх хувилбар болон дараах хувилбарын аль алиныг нь харж болохоор хөгжүүлэх шаардлагатай.

2. *Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах цахим систем боловсруулах үүднээс:*

- Энэхүү ажиллагааны хувьд АНУ болон ОХУ-ын цахим хуудсуудын загвар, бүтцийг судлах, тэдний туршлагыг нутагшуулах арга замыг эрэлхийлэх нь зүйтэй. Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх үе шатыг ил тод, дэлгэрэнгүй байдлаар байршуулснаар нэлээд чамбай, сайн хууль батлагдах үндэс болно.
- АНУ болон дэлхийн бусад оронд сүүлийн жилүүдэд эрчимтэй нэвтэрч буй хуулийн төслийг хянаж, засварлаж, кодолдог хувь хүн, хуулийн этгээдийн цахим хуудсыг нэвтрүүлэхээс илүүтэйгээр одоо байгаа цахим хуудсуудаа боловсронгуй болгох, үйл ажиллагааг нь сайжруулах шаардлагатай. Тодруулбал, хуулийн төсөл хэлэлцэхтэй холбоотой баримт бичиг, хэлэлцүүлгийн тэмдэглэл, хэлэлцүүлэгт оролцсон гишүүдийн санал, тоо баримт зэргийг нарийвчлан оруулах гэх мэт.



## ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

### Нэг. Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль, *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (1992), №1
- Хууль тогтоомжийн тухай хууль, *Төрийн мэдээлэл* эмхэтгэл (2015), №25

### Хоёр. Ном зохиол, гарын авлага, судалгааны тайлан

#### *Монгол хэлээр*

- Амарсанаа.Б. *Харьцуулсан эрх зүй судлал*, 2 дахь хэвлэл. УБ: МУИС Пресс, 2014.
- Амархүү.О. *Эрх зүйн онолын арван таван сэдэв*. УБ: Адмон хэвлэл, 2008.
- Лүндээжанцан.Д. *Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник*. УБ: ВСИ хэвлэл, 2010.
- Нарангэрэл.С. *Эрх зүйн эх толь бичиг*. УБ: Адмон хэвлэл, 2007.
- Түвшинтулга.А. нар. *Хууль зүйн арга ажиллагаа /эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл/* (УБ: ХЗҮХ-гийн хэвлэх үйлдвэр, 2018).

#### *Гадаад хэлээр (Орос)*

- Кашанина.Т.В. *Юридическая техника*. Москва: Норма-Инфра-М, 2011.

### Гурав. Судалгааны тайлан, илтгэл өгүүлэл

#### *Монгол хэлээр*

- Чимид.Б. “Хууль тогтоомжийг системчлэхэд Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэлийн онол, практикийн ач холбогдол” (УБ: 2010).

#### *Гадаад хэлээр (Англи)*

- Gunther A.Weiss “The Enchantment of Codification in the Common Law World” *Yale Journal of International Law* (2000) 8 (25).

### Дөрөв. Цахим эх сурвалж

- “Detailed guide to the united states code content and features”, [http://uscode.house.gov/detailed\\_guide.xhtml](http://uscode.house.gov/detailed_guide.xhtml)
- Municode - <https://www.municode.com/codification-and-recodification/#footer>
- Open Law Library - <http://www.openlawlib.org/platform/open-law-codify/>
- Rohit Kumar “Advantages and Disadvantages of Codification of Law”, <https://lawjugaad.com/codification-of-law-meaning-advantages-and-disadvantages-of-codification-condition-for-codification-classification-of-code-and-codification/>
- АНУ-ын Мужуудын хууль тогтоомжийн цахим сан - <https://statelaws.findlaw.com/>
- АНУ-ын Хууль тогтоомжийн нэгдсэн сан - [www.congress.gov](http://www.congress.gov)
- АНУ-ын Хууль тогтоомжийн нэгдсэн сан - [www.govinfo.gov](http://www.govinfo.gov)
- АНУ-ын Хууль тогтоомжийн хялбаршуулсан сан - <http://www.loc.gov/law/help/guide.php>
- АНУ-ын Эрх зүйн мэдээллийн хялбаршуулсан хуудас - <https://www.alllaw.com/>,

- Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан - [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)
- Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан – [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
- ОХУ-ын Төрийн Думын хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх нэгдсэн сан - <http://sozd.duma.gov.ru/>
- ОХУ-ын эрх зүйн актын нэгдсэн сан - <http://www.consultant.ru/>
- ОХУ-ын эрх зүйн актын нэгдсэн сан - <http://www.garant.ru/>
- ОХУ-ын эрх зүйн актын нэгдсэн сан - <https://kodeks.ru/>
- Улсын Их Хурлын цахим хэлэлцүүлгийн хуудас - <http://forum.parliament.mn/>
- ХБНГУ-ын Бундесратын албан ёсны цахим хуудас - <https://www.bundesrat.de>
- ХБНГУ-ын Бундестагийн албан ёсны цахим хуудас - <https://www.bundestag.de>
- ХБНГУ-ын Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн сан - <http://www.verwaltungsvorschriften-im-internet.de>
- ХБНГУ-ын Мужийн хууль тогтоомжийн нэгдсэн сан - <https://justiz.de/bundlaender/index.php>
- ХБНГУ-ын Холбооны хуулийн эмхэтгэлийн цахим хувилбар - <https://www.bgb1.de/>
- ХБНГУ-ын Шүүхийн шийдвэрийн цахим сан - <https://www.rechtsprechung-im-internet.de>
- ХБНГУ-ын Эрх зүйн актын нэгдсэн сан - <https://www.gesetze-im-internet.de/index.html>
- Хууль зүй, дотоод хэргийн яамны албан ёсны цахим хуудас - [www.mojha.gov.mn](http://www.mojha.gov.mn)